



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛДЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амьн хөгжил, нийгмийн хамгааллын сайдын /хуучин нэрээр/ 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/52 тоот тушаалаар баталсан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын 3.2, 9.2 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

"3.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүдийг томилж, чөлөөлнө."

"9.2.Сум, хорооны нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавьж ажиллах ба энэ талаарх тайлан, мэдээллийг аймаг, дүүргийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дараа сарын 10-ны дотор хүргүүлнэ".

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн "...90..." гэснийг "...30...", "...10..." гэснийг "...45..." гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "...90..." гэснийг "...30..." гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хассугай.

4. Энэ тушаалыг 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

САЙД



Н.НОМТОЙБАЯР